## БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 оны 01 дүгээр сарын 15 — Номгон

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт-1. Байгууллагын албан хаагчдын ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах** | | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1.1 | Аймгийн ЗДТГ-ын 2024 онд ажиллах бүтэц орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоож, төрийн үйлчилгээний албанд шинээр орсон албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах | - | Батлагдсан бүтэц орон тоо, шинээр байгуулсан хөдөлмөрийн гэрээний тоо | Орон тоо-100 Хөдөл мөрийн гэрээ-12 | Орон тоо-103 Хөдөл мөрийн гэрээ-15 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны Б/01 тушаалаар 97 орон тоог батлуулан, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны алба хаагчдын цалингийн санг шинэчлэн тогтоож ажилласан. Мөн Төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон нийт 9 алба хаагчтай хөдөлмөрийн гэрээг шинээр болон шинэчлэн байгуулсан байна. | 100% |
| 1.2 | Аймгийн хэмжээний ТАХ-ын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах | - | Хөтөлбөр батлуулсан байх, хэрэгжилтийн хувь | 0% | 100% | Төрийн аудитын газраас 2024 оны 09-11 дүгээр сар хүртэл 2 сарын хугацаанд хүний нөөцийн аудит хийгдэж хүний нөөцийн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж ирүүлсэн. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратеги төлөвлөгөөний төслийг "Удирдлагын баг"-т танилцуулж сайжруулалт хийж байна. Аймгийн хэмжээний | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дутагдалтай орон тоог нөхөх, нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр Боловсролын яаманд хүсэлт гарган Баянхонгор аймгаас их дээд сургуульд суралцаж байгаа нийт оюутнуудын судалгааг авч мэдээллийн бааз бүрдүүлэн ажилласан. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2025 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 186 дахь заалт /60,0 сая төгрөгийн төсөвтэй/, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.14.2 заалтаар тус тус тусгасан . | |
| 1.3 | Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | Сургалт зохион байгуулагдсан байх<br>Мэдлэг чадвар 30 хувь дээшилсэн байна. | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг зохион байгуулах ажлын хэсэг, сургалт зохион байгуулах ажлын төлөвлөгөө, сургалтад зарцуулагдах төсвийн тооцоог аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар баталж 2024 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны сургуулийн захирал, доктор проф. Б.Баясгалан, Доктор Г.Жаргал, Сургагч багш Ц.Үүрийнтуяа нартай хамтран зохион байгууллаа. Нийт 19 сумын 97 багийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг дарга буюу 92.4 хувь нь идэвхтэй хамрагдаж Удирдлагын академийн богино хугацааны сургалтын гэрчилгээгээ гардан авлаа. Шилдгийн шилдэг оролцогчоор Эрдэнэцогт сумын Ямаат 2 дугаар багийн Засаг дарга Д.Эрдэнэчулуун болон шилдэг сургагч багш, менежерээр Б.Наранцэцэг нар шалгарч БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтэд (LOGODI) туршлага судлах сургалтад хамрагдсан. | |
| 1.4 | Удирдлагын академийн 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | 2-3 томоохон арга хэмжээ зохион байгуулсан байна. | 0 | 2 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/170 дугаар захирамжаар Удирдлагын академийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэх ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хүрээнд ажлын хэсэг нэг удаа хуралдаж түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Намын дээд сургуулийн ахмад төгсөгчид, үе үеийн төгсөгчдийн төлөөлөл “НАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ, УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ТӨГСӨГЧДИЙН НЭРЭМЖИТ НОГООН ТӨГӨЛ” байгуулж, нийт төгсөгчдөөс 8,0 сая төгрөг хандивласан. | 100% |
| 1.5 | ISO 9001 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх | Байгууллагын төсөв | Стандартын хэрэгжилтийн хувь | 40% | 100% | ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/76 дугаар тушаалаар “Чанарын баг”-ийг байгуулан Тэнүүн сэтгэмж ХХК-аас 3 удаагийн зөвлөх үйлчилгээг авч, Кю сертф ХХК-аар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөндлөнгийн үнэлгээг хийлгэн, 89.8 хувийн тохиролтойгоор "Баталгаажуулалтын гэрчилгээ"-г 3 жилийн хугацаатай авсан. Байгууллагын хүрээнд дотоод аудитыг 2 удаа хийж, сайжруулах 4 саналыг дээд удирдлагад мэдээлсэн. Хөндлөнгийн аудитаар илэрсэн 5 жижиг үл тохирлыг залруулсан. Удирдлагын дүн шинжилгээний хурлыг 2 удаа хийж, стандартын хэрэгжилтийг тасралтгүй сайжруулах чиглэлээр шийдвэр гарган ажиллаж байна. | |
| 1.6 | Төрийн болон орон нутгийн шагнал, урамшууллыг хууль, журамд нийцүүлж олгох | - | Шагнагдсан иргэдийн тоо | 125 | 130 | Аймгийн Засаг даргын Тамгын газарт Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч шаардлага хангасан материалыг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэн ажилласан. Тайлант онд Ерөнхийлөгчийн Тамгын газарт нийт 595 иргэний материалыг албан бичгээр уламжлан хүргүүлж able программд бүртгэсэн байна. Ламын гэгээний 385 жилийн ойн баярын хурлын арга хэмжээнд нийт 152 иргэн Төрийн дээд одон медаль болон салбарын шагналаар шагнагдсан. | 100% |
| 1.7 | Алдарт эхийн одонгийн материалыг журмын дагуу хүлээн авч нэгтгэх, хүргүүлэх, олгох ажлыг зохион байгуулах | - | Шагнагдсан иргэдийн тоо | 309 | 310 | Аймгийн хэмжээнд нийт 330 эхийн материалыг хүлээн авч холбогдох журмын дагуу шалгаж шаардлага хангасан 324 эхийн материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлан шийдвэрлүүлсэн. 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Алдарт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эхийн нэг, хоёрдугаар одон гардуулах ёслолын арга хэмжээг Усан бассейн спорт цогцолборт амжилттай зохион байгуулж 221 эхэд алдарт эхийн нэг, хоёрдугаар одонг амжилттай гардуулан амжилттай зохион байгуулж ажилласан. | |
| 1.8 | Байгууллагын алба хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэг болон спортоор хичээллэх үйл ажиллагааг зохион байгуулах | Байгууллагын төсөв | Албан хаагчдын тоо | 0 | 100 | Төрийн байгууллагуудын дунд 1 удаа, байгууллагын албан хаагчдын дунд 4 удаа спортын тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Албан хаагчдын дунд спортын арга хэмжээ зохион байгуулснаар албан хаагчдын бие бялдрын хөгжлийг сайжруулж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилсан сэргийлсэн ажил арга хэмжээ болсон. “Баруун бүсийн аймгуудын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дундах” спортын бага наадамд-Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй, эмэгтэй баг “Тэргүүн байр”, Волейболын төрөлд эрэгтэй баг “Тэргүүн байр”, эмэгтэй баг “Дэд байр”, Дартсын төрөлд эрэгтэй “Тэргүүн байр”, эмэгтэй “Гутгаар байр”, Шагайн харвааны төрөлд “Гутгаар байр”, Шатрын төрөлд эрэгтэй “Гутгаар байр”, Тамгын газрын дарга нарын дундах буудлагын тэмцээнд “Тэргүүн байр”, эрэгтэй, эмэгтэй “Шилдэг тамирчин” Э.Золзаяа, Б.Эрдэнэмөрөн шалгарч нийт дүнгээр “Дэд байр” эзэлсэн амжилттай оролцлоо. “Эрүүл мэндийг эрүүлээр өөрчилье” аяны төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хүрээнд “Нарны алхалт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шугаман бүжиг, 11 цагийн дасгалыг бүх албан хаагчид хийж байна. Мөн албан хаагчдын шүдний эрүүл мэндийн талаар сургалтыг зохион байгуулж 5 албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх эрх олгосон. Спортын болон эрүүл мэндийн арга хэмжээнд байгууллагын нийт албан хаагчид хамрагдсан. | |
| 1.9 | Байгууллагын эцэг, эхийн зөвлөл болон Хүүхдийн өрөөний тохижилт, үйл ажиллагааг сайжруулах, хяналт тавих | Байгуул лагын төсөв | Хэрэгжилт | - | - | Байгууллагын албан хаагчдын гэр бүлийн гишүүн, хүүхдүүдийн дунд спортын олон төрөлт нөхөрсөг арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Мөн гэр бүлийн өдрөөр Баянхонгор сумын ЗДТГ-аас зохион байгуулсан аав, ээж, би тэмцээнд байгууллагын албан хаагчдыг урилан 1 гэр бүлийг оролцуулсан. Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн олонх нь өөр байгууллагад шилжин ажилласан тул зөвлөлийг шинэчлэх саналыг байгууллагын тайлангийн хурлаар танилцуулсан. Эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын амрах өрөөг бий болгох, хүүхдийн өрөөний ашиглалтыг сайжруулах талаар хамт олны хурал дээр санал авч байгууллагын барилгын асуудал шийдвэрлэгдсэний дараа шийдвэрлэхээр тогтсон. | 100% |
| 1.10 | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа улс, бүс, аймгийн чанартай уулзалт, зөвлөгөөн, уралдаан, тэмцээнийг чанарын өндөр түвшинд | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 3 | Ламын гэгээний 380 жилийн ойн арга хэмжээ, Монголын тэмээн соёл улсын зөвлөгөөн, Улаанбаатар, Дархан-Уул, Эрдэнэт хотуудад "Нутгийн зөвлөлийн золголт", аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөн, Алдарт эхийн одон | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | | гардуулах үйл ажиллагаа, Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт, УИХ-ын даргын албан айлчлал зэрэг томоохон үйл ажиллагаануудыг тухай бүр нь амжилттай зохион байгуулсан. | |
| **Зорилт-2. Цахим технологид тулгуурлан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлэх, ил тод байдлыг сайжруулах** | | | | | | | |
| 2.1 | Төрийн албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах. /ЗДТГ, ИТХ, Санхүүгийн хяналт дотоод аудит/ | 220 сая Орон нутгийн хөгжлийн сан | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 50 | 60 | Аймгийн Засаг даргын Тамгын газарт зөөврийн компьютер 5, принтер 6, өнгөт принтер 1, LED дэлгэц 1, дуу хураагуур 2, суурин компьютер 15 ширхэг, Сумдын ИТХ-д суурин компьютер 20, принтер 10, зөөврийн компьютер 1, Сумдын ЗДТГ-т өнгөт принтер 20, 3 үйлдэлд принтер 20, Санхүү, хяналт дотоод аудитын хэлтэст зөөврийн компьютер 3, Суурин компьютер 5 ширхэг төхөөрөмж тус тус хүлээлгэж өгсөн. Албан хаагчдын тоног төхөөрөмжийн хангалтыг 60 хувьд хүргэсэн. | 100% |
| 2.2 | Багийн Засаг дарга нарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 132,32сая Орон нутгийн хөгжлийн сан | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 50 | 70 | Багийн Засаг дарга нарт 77 ширхэг зөөврийн компьютер, 74 ширхэг 3 үйлдэлт принтер тус тус олгож төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлж, багийн дарга нарын ажиллах нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангалтын хувийг 100 хувьд хүргэсэн. | 100% |
| 2.3 | Орон нутгийн онцлогтой төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх. | 18,00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга | 100-аас багагүй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр | 28 | 128 | И-МОНГОЛ УТҮГ-ын ажлын хэсэг 2023 оны 11 сарын 25-аас 12 сарын 01-ний өдрүүдэд Баянхонгор аймагт ажилласан. Төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний зардал | | | | холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгуулж цахимд шилжүүлэх боломжтой 128 төрлийн үйлчилгээний жагсаалтыг гаргаж, үйлчилгээний чанарыг сайжруулах, нэмэгдүүлэх, дахин загварчилсны дагуу 6 төрлийн үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Тайлант онд нийт 39 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг нэвтрүүлэн үйлчилгээг цахимаар авах бүрэн боломжийг бүрдүүлсэн. Цаашид үйлчилгээний тоог улсын хэмжээнд 1 стандартын дагуу нэвтрүүлэх учраас хүлээгдэж байна. | |
| 2.4 | Баянхонгор сумын 10 дугаар багийн иргэдийн цахим мэдээллийн нэгдсэн системтэй болгох. | 30,00 Орон нутгийн хөгжлийн сан | Гүйцэтгэл | 0 | 100 | Тухайн ажлыг хийх санхүүжилтийн эх үүсвэр байхгүй улмаас тендер зарлагдаагүй, ажил хийгдээгүй болно. | 0% |
| 2.5 | Байгууллагын дотор, гадна камержуулалтыг сайжруулах, бүрэн ажиллагаанд оруулж, бичлэгийн нууцлалыг хамгаалах | Орон нутгийн хөгжлийн сан | Гүйцэтгэл | 0 | 16 | Байгууллагын дотор болон гадна нийт 18 камерыг шинээр суурилуулан, камерын хэвийн үйл ажиллагааг өдөр тутамдаа хянаж, бичлэгийн нууцлалыг хамгаалан ажиллаж байна. | 100% |
| 2.6 | Байгууллагын албан хаагчдын өрөө, танхимын хаягжилт, мэдээллийн самбарын ил тод байдлыг хангах | 1.276.0 Байгууллагын төсөв | Гүйцэтгэл | 0 | 42 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 43 өрөөний нийт 72 алба хаагчийн хаягийг 2024 оны эхний хагас жилд багтаан 100 хувь бүрэн сольж, шинэчлэн байршуулсан. Мөн иргэдэд зориулсан чимэзгүй хөтөч самбарыг шинээр хийж байгууллагын 1,2,3 дугаар давхарт тус тус байршууллаа. Тайлант онд шинээр батлагдсан Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ- | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, аймгийн статистик мэдээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, үзүүлэх үйлчилгээ, тусгай зөвшөөрөл, өргөдөл, гомдол шийдвэрлэлт, худалдан авах ажиллагаатай холбоотой давхардсан тоогоор 150 гаруй мэдээллийг байгууллагын ил тод байдлын мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллалаа. | |
| **Зорилт 3. Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэн холбооны гишүүн орнуудтай харилцаа холбоогоо улам өргөжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлж, худалдаа эдийн засгийн харилцааг шинэ түвшинд хүргэх** | | | | | | | |
| 3.1 | Хамтын ажиллагаатай улс орнуудтай олон талт уулзалт зохион байгуулж, сайн туршлагыг орон нутагт хэрэгжүүлэх. | 40 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Муж аймаг орон нутгийн хоорондын хэлэлцээрийн тоо | 4 | 6 | -Унгар улсын Веспрем хоттой эдийн засгийн хөгжил, хөдөө аж ахуй, боловсрол, аялал жуулчлал, соёлын солилцоо чиглэлээр “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, Баянхонгор аймгаас ажиллах хүч ажиллуулах, оюутан сургах асуудлаар талууд зөвшилцөлд хүрсэн.<br>-ЕБС-ийн 9 сурагчийг БНХАУ-д соёлын солилцооны хөтөлбөрт хамруулж, орон нутгийн соёлыг сурталчилж ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгын хүрээнд Баянхонгор аймгийн цөлжилтийг саарууах зорилгоор БНХАУ-ын Ниншя Хуй-ӨЗО-д “Цөлжилттэй тэмцэх арга аргачлал” танхим, практик хосолсон сургалтад байгаль орчны чиглэлийн 14 албан хаагчийг хамруулж, чадавхжуулсан.<br>-Хунан мужид зохион байгуулагдсан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | экологийн соёл иргэншил болон аялал жуулчлалын хөгжлийн нөөцийн тогтвортой хөгжлийн туршлагаас хуваалцах "Байгальд ээлтэй хөгжил" сэдэвт хуралд аймгийн ЗДТГ-ын Байгаль орчин уул уурхай, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны газрын дарга нар оролцсон. Тухайн онд байгаль орчны салбарын албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах ажлыг өмнөх онуудтай харьцуулахад өргөн цар хүрээтэй зохион байгуулж, туршлагаа хэрэгжүүлэхээр аймгийн бодлогын баримт бичгүүдэд байгаль орчин, ногоон байгууламж, цөлжилтийн эсрэг хэрэгжүүлэх саналуудаа тусгасан. Эрдэнэ монгол ХХК Шинэжинст сумын нутаг дэвсгэрт 1 га газарт элсний нүүдлийг сааруулах зорилгоор дөрвөлжин тариалалтын аргаар мод тарих туршилтыг хийхээр төсөв хөрөнгийг шийдүүлсэн байна.<br>-Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел сангийн Монгол дахь төслийн зохицуулагч, доктор Хью Парсонсоор ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажиллаж, айлчлалын үр дүнд Баянхонгор аймгийн аймгийн 20 суманд Канад улсын Лаурел сан, Эрдэнэ ресурс, Эрүүл мэндийн яамтай хамтран нүдний өвчний эрт илрүүлэг, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, дадал олгох | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон. -Япон Улсын эрдэмтэдтэй хамтран Монгол орны хөрс, цаг уурт тохирсон шингэн бордоог үйлдвэрлэхээр Баянхонгор аймгийн Өлзийт-ХАА МСҮТ-тэй хамтран судалгаа, үйлдвэрлэлийн туршилтын ажил эхэлсэн. -Төр, хувийн хэвшлийн 13 мэргэжилтэн байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр Ганьсу мужид 8-20 хоногийн сургалтад хамрагдаж тухайн орон нутгийн цөлжилттэй тэмцсэн болон өвлийн хүлэмжийн аж ахуйг эрхлэх арга туршлагатай танилцаж, мэдлэг туршлага хуримтлуулсан. -БНХАУ-ын Гансу мужид 10 оюутныг инженерийн чиглэлээр элсүүлж, сургаж байна. -ХААИС-ын Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн 15 багш, оюутан Ганьсу мужийн Жичюань хотын коллежид туршлага судалсан. | |
| **Зорилт-4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих** | | | | | | | |
| 4.1 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах. | 10 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хэрэгжилт | 30 | 50 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/47 дугаар захирамжаар батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат 60 удаагийн сургалтыг 147 сэдвийн хүрээнд 9211 иргэд төрийн албан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагч зорилтот бүлгүүд рүү чиглүүлэн зохион байгуулж эрх зүйн ойлголтыг нь нэмэгдүүлсэн. Төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна. | |
| 4.2 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | 5 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Авлигын гэмт хэргийн тоо, Шударга байдлын үнэлгээний хувь, Цахим хуудасны ил тод байдлын хувь | 5<br>70<br>45.8 | 2<br>72<br>48 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар баталж, төлөвлөгөө 100 хувьтай биелсэн. Энэ онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 17 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Цахим хуудасны ил тод байдал 100 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 6.7 хувиар өссөн байна. | 100% |
| 4.3 | Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | 2 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хэрэгжилт | 80 | 90 | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн заалт Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоол, 2023 оны 256 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын 01 дүгээр тогтоолын хүрээнд Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Аймгийн Засаг даргын 2024 оны А/13 дугаар захирамжаар 3 зорилт 12 арга хэмжээг батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. сургалтын дараах судалгаагаар сургалтад хамрагдсан хүний 83,5 хувь эрх зүйн мэдлэг дээшилсэн гэсэн байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297, 360 дугаар тушаалаар батлагдсан Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишгийг олон нийтэд сурталчлан таниулах. | 3,00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Сурталчилгааны хувь | 0 | 20 | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297, 360 дугаар тушаалаар батлагдсан Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишгийг олон нийтэд сурталчлах чиглэлээр гарын авлага 3600, плакат 500 ширхгийг бэлтгэн хэвлүүлж, 20 сумын 3470 гаруй иргэдэд түгээж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 4.5 | Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг төлбөртэй авах арга хэмжээг зохион байгуулах. | 2,0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Төлбөртэй авсан мэдээлэл | 0 | 2 | Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг төлбөртэй авах арга хэмжээг 20 сумын 3470 иргэнд гарын авлага 3600, плакат 500 ширхгийг бэлтгэн хэвлүүлж, мэдээлэл өгч тараасан мөн Цагдаагийн газарт чиглэл хүргүүлэн ажиллалаа. Тайлант онд иргэнээс гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг өгөөгүй байна. | 100% |
| 4.6 | Террозимтэй тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | 3 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | 1 | 2 | Террозимтэй тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 4.7 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийг үйл ажиллагааг эрчимжүүлэх. | 2 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо | 27 | 26 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулан Засаг даргын 2024 оны А/195 дугаар захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо 3-аар буурч төлөвлөгөөний биелэлт 100% байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.8 | Үндэсний аюулгүй байдлыг мэдээ мэдээллээр хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах. | 5 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | хэрэгжилт | 80 | 90 | Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/16 дугаар захирамжаар батлуулан, 5.0 сая/төг-ийг шийдвэрлүүлж, 100 хувьтай биелсэн. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулсан. Аймгийн хэмжээний хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалтыг хийж, зөрчлийг арилгуулан ажиллаж, Эрхэмсэг оршихуй эмэгтэйчүүд рүү чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. | 100% |
| 4.9 | Төрийн архивыг 44 нягтруулсан шүүгээгээр хангах. | 60 сая Орон нутгийн хөгжлийн сан | Нягтруулсан тавиур шүүгээний хангалт | 80% | 90% | Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60 сая төгрөг батлуулан Худалдан авах үйл ажиллагаагаар нийт 72 нягтруулсан шүүгээ худалдан авч, сан хөмрөгт байршуулан угсруулж, Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний А/289 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авснаар архивын 5200 нэгжийн хадгалж хамгаалах нөхцөлийг сайжрууллаа. | 100% |
| 4.10 | Төрийн архивд хадгалагдаж байгаа дуу дүрсний баримтыг сэргээн хуулбарлаж, цахим. санд шилжүүлэх, хадгалалт хамгаалалт, сайжруулах | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Сэргээн хуулбарлаж, цахим санд шилжүүлсэн баримт | 0 | 9839 | Төрийн архивд хадгалагдаж байгаа дуу дүрсний баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Засаг даргын 2024 оны А/179 дүгээр захирамжаар 20 сая төгрөг шийдвэрлүүлэн дуу дүрсний баримтыг сэргээн хуулбарлаж, цахим санд шилжүүлэх ажлыг эхлүүлэхээр Тусгай | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техник тоног төхөөрөмжийг түрээслэх болон бусад үйл ажиллагаанд гэрээ байгуулж дуу, дүрсний баримтыг 8-11 дүгээр саруудад хуулбарлан Тамгын газрын даргын 2024 оны А/625 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авснаар дуу дүрсний бүх баримтыг шинэчлэн сэргээн хуулбарлаж, үндсэн болон нөөц сервер, ашиглалтын хардуудад хуулбарлаж ажилласан нь баримтуудын насжилт чанарыг 50-80 хүртэл хувьд хүргэж сайжрууллаа. | |
| 4.11 | "Цахим архив-Баянхонгор" хөтөлбөрийн үр дүнг тооцох. | 3 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Зохион байгуулсан арга хэмжээ, урамшуулсан ажилтан | 0 | 100 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/646 дугаар захирамжаар "Цахим архив-Баянхонгор" хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн Эрдэм шинжилгээний бага хурлыг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж 212 ажилтан оролцож, Сан үүсгэгч байгууллагын 2001-2021 оны түүхэн хугацааны 175000 хадгаламжийн нэгж, баримтыг Төрийн архивд цаас болон цахим хэлбэрээр шилжүүлсэн, хүлээн авсан түүхэн үр дүнг сайшааж, хамгийн олон баримт шилжүүлсэн, хамгийн олон жил үр дүнтэй ажилласан 45 ажилтныг Манжуур хотод аялах эрхээр аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат шагнаж урамшууллаа. | 100% |
| 4.12 | Хэрэглэгчийн эрхийн хангах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | 4,2 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хэрэгжилт | 95 | 100 | Хэрэглэгчийн эрхийг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого шийдвэр, зорилт, чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Засаг даргын А/14 дүгээр захирамжаар 3 зорилт 16 ажил арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, 100 хувьтай. Аймгийн хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 37 удаагийн сургалтыг зохион байгуулж, 5157 иргэн, төрийн албан хаагч сурагчдыг хамруулсан. Урьдчилан сэргийлэх зөрчил арилгах хяналтыг 25 удаа зохион байгуулж шалгалтад 286 объект хамрагдаж 13 аж ахуйн нэгжид албан шаардлага өгч 306 нэр төрлийн 17.035.950 төгрөгийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг устгаж зөрчлийг арилгуулж хэрэглэгчийн эрхийн зөрчил 57.6 хувиар буурсан байна. | |
| 4.13 | Баянхонгор аймгийн төрийн архивын аюулгүй байдлыг хангах галын хийн системийн цэнэглэлт үйлчилгээ хийх ажлыг хийж гүйцэтгэх. | 20,00<br>Их засварын зардал | Гүйцэтгэл | 0 | 100 | Төрийн архивын аюулгүй байдлыг хангах галын иж бүрэн тоноглох, цэнэглэлт, засвар үйлчилгээг хийлгэхээр аймгийн Засаг даргын 2024 оны А/627 дугаар захирамжаар 20.0 сая/төг-ийг зарцуулж, “Дэнж зэс” ХХК-тай гэрээ байгуулан Онцгой байдлын газрын хяналт дор галын 120 иж бүрэн тоноглол хүлээн авч, гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжиж Архивын хадгалалт хамгаалалт стандартын шаардлагыг 30 хувиар сайжруулсан | 100% |
| 4.14 | Шуурхай удирдлагын төвийг байгуулах. | 200,0<br>Орон нутгийн хөгжлийн сан | Гүйцэтгэл | 10 | 50 | Мэдээлэл шуурхай удирдлагын төв”-г байгуулахаар орон нутгийн төсвөөс 200.0 сая /төг-ийг батлуулан, тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, Айети юнипикэшн ХХК шалгарч, гүйцэтгэл 100% болж, нээлтийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хийж, ашиглалтад оруулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5. Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх** | | | | | | | |
| 5.1 | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах. | 814,10 Орон нутгийн төсөв | Малын тоо | 3.0 сая | 6.0 сая | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэн дархлаажуулалтад 1,6 сая толгой мал хамруулсан. Мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Үхэр-171395, Гахай- 175 нийт-171570 мал, амьтан, "Хонины цэцэг" өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 12 сумын 2356 өрхийн 694001 бог малыг, "Бог малын мялзан" өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4 сумын 560 өрхийн 447230 бог малыг хамруулан 99,3%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Мөн шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэн арга хэмжээнд арга хэмжээ буюу Угаалга-1.0 сая, Туулга-1.0 сая, боловсруулалт - 432.7 мянга, гуурын боловсруулалт - 22,9 мянга буюу нийт 2.5 сая толгой малыг хамруулж 92.7%-тай хэрэгжүүлсэн. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 4,1 сая толгой мал хамруулж халдварт өвчний гаралт өмнөх оныхоос 56 хувиар буурсан байна. | 100% |
| 5.2 | Хөдөө аж ахуйн салбарын дутагдалтай мэргэжилтэн бэлтгэх. | 40,0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх | Суралцагч | 19 | 19 | Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжлээр сурч буй оюутнуудад сургалтын төлбөрийн | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний зардал | | | | дэмжлэг үзүүлж тайлант онд 3 оюутан төгсөж ажлын байран дээр ажиллаж байна. Мөн 2 оюутан жилийн чөлөө авч, 5 оюутан хангалтгүй суралцсан тул төлбөрийг нэхэмжлэхээр болж тэтгэлгийг түдгэлзүүлсэн. 2024-2025 оны хичээлийн жилд үлдсэн 10 оюутны сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэхээр 22,4 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсвөөс олгосон. Мөн аймгийн Хөдөө аж ахуйн газрын 3 мэргэжилтэн Зохиомол хээлтүүлгийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдан мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн тул сургалтын төлбөрт 3,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Нийт нийт хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн 60 хувийг бүрдүүлээд байна. | |
| 5.3 | Малчдын бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах. | 5,00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Зөвлөгөөнд оролцсон малчид | 0 | 500 | Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, нийлүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотод 120, Өвөрхангай аймагт 88, Архангай аймагт 65, нийт 273 малчин, хоршооны төлөөллийг бүсчилсэн байдлаар уулзалт, сургалтад хамруулллаа. | 100% |
| 5.4 | Баталгаажсан үүлдэр омгийн малд шилэн сонголт хийх. | 19,00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Малын тоо | 12000 | 13500 | Баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг, ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, малын генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох зорилгоор улсын төсвийн 26.4 сая төгрөг, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн төсвийн 19.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн. Хавар, намрын технологит хугацаанд Залаажинст-Эдрэн үүлдэр, Бөмбөгөрийн улаан омгийн 7645 үржлийн ямаа, Ламын гэгээний улаан үүлдрийн 620 тэмээ, Байдраг үүлдрийн 1996 хонь, Баянбулаг омгийн 1482 хонь, нутгийн 2506 сарлаг бүгд 14249 толгой малыг үзлэг ангилалтад хамруулж, ашиг шимийн түвшинг тогтоосон. Тухайн үүлдэр омгийн мал үүлдэр, омгоор батлагдах үеийн амьдын жингээс Залаажинст-Эдрэн үүлдрийн болон Бөмбөгөрийн улаан омгийн ямаа нас хүйс тус бүрдээ 1,1-7 кг-аар, Баянбулаг омгийн хонь нас, хүйс тус бүрдээ 1,2-15,5 кг-аар, нутгийн монгол сарлаг 20 кг-аар, Ламын гэгээний улаан үүлдрийн тэмээ нас хүйс тус бүрдээ 56-75 кг-аар тус тус нэмэгдсэн дүнтэй байна. Үзлэг ангилалтад хамрагдсан малаас шилэн сонголт хийж, бусад өрхийн малын чанарыг сайжруулах үржлийн мал бойжуулах зорилгоор цөм сүргийн 10526 хээлтэгч, хээлтүүлэгч малыг сонгон үржлийн цөм сүрэг бүрдүүлсэн. Үүнд: үржлийн 1924 сарлаг, 812 тэмээ, 2953 эм хонь, 4837 эм ямаагаар цөм сүргийн мал бүрдүүллээ. | |
| 5.5 | Бод малд зохиомол хээлтүүлэг хийх. | 19,80 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Гарсан төлийн тоо | 0 | 100 | 2023 онд 82 ухэрт зохиомол хээлтүүлэг хийсэн бөгөөд 2024 оны хавар 66 төл хүлээн авч 80 хувийн үр дүнтэй хэрэгжүүлсэн. Зохиомол | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хээлтүүлэг шалгах багаж тоног төхөөрөмж байхгүйгээс технологийн алдаа гарч үр дүн буурсан. 2024 онд бод малд зохиомол хээлтүүлэг хийхээр 19,0 сая төгрөгийг санхүүжилтийг баталсан. Энэ дагуу Бөмбөгөр, Баацагаан, Баянхонгор сумын 6 өрхийн 100 үнээ, Жинст сум ОНХС-ын 10,0 сая төгрөгөөр 50 үнээнд тус тус зохиомол хээлтүүлэг хийсэн. Намрын хээл шалгалтаар 80% үр дүнтэй. | |
| 5.6 | Шинэжинст сумын Залаажинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах. | 20,00 Орон нутгийн хөгжлийн сан | Гүйцэтгэл | 0 | 10 | "Залаа зөвлөл" ТББ судалгааг хийж 20,0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан. Судалгаагаар Залаажинстийн цагаан ямаан сүргийн малчид тухайн жилийн ямааны зарлагаа бойжуулсан төлөөрөө нөхөн үйлдвэрлэж чадахгүй байна. Үүний улмаас ямаан сүргийн тоо толгой хорогдож, малчид хэрэглээгээ хангахын тулд гадны аймаг, сумаас ямаа худалдан авч өсгөж байгаа нь сүргийн доторх өөр зүсний ямааны тоо толгойг өсгөхөд нөлөөлж ашиг шимийн үзүүлэлт буурах хандлагатай байгааг тодорхойлсон байна. | 70% |
| **Зорилт 6. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, геологи, уул уурхайн бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 6.1 | "Эко сум" сургалт зохион байгуулах. | 10.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Зохион байгуулсан сум | 0 | 3 | Сумдын удирдлагууд болон байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах цогц менежментийн ойлголт өгөх "Эко сум- | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хог хаягдлын тогтвортой менежмент" сургалтыг 2024 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Каритас Чех Репаблик олон улсын байгууллага, Экосум ТББ, Монголын Байгаль орчин аюулгүй байдлын төв ТББ, Монголын тогтвортой хөгжлийн гүүр ТББ-ууд хамтран Европын холбооны SWITCH-Asia хөтөлбөрийн санхүүжилттэйгээр "Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төслийг 2020-2024 оны хооронд Булган аймгийн Хишиг-Өндөр суманд хэрэгжүүлж байгаа ба тус төслийн хүрээнд аймаг, орон нутагт хог хаягдлын менежментийг үр дүнтэй тогтолцоог бий болгох, хуванцар дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд 4 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн туршилтын төсөл, судалгааны тайлан, хэрэгжүүлсэн үр дүнтэй ажлууд болон сургамжит алдаануудын талаар танилцуулсан нь сумдад шууд хэрэгжүүлэх боломжтой, тодорхой үр дүнтэй байв. Цаашид Булган аймгийн Хишиг-Өндөр суманд хэрэгжүүлсэн тус төслийг улсын хэмжээнд 11 сум сонгон хэрэгжүүлэх ба сонгон шалгаруулалтад оролцох боломжоор сумдыг хангаж мэдээлэл өгөв. | |
| 6.2 | Баянхонгор сумын ус хангамжийн эх үүсвэрийг | 144,00 Хөгжлийн | Хашаажуулсан эх үүсвэрийн тоо | 0 | | Орон нутгийн хөгжлийн сангийн 144.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хашаажуулах. | төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | | | | Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрийг бүрэн хашаажуулсан. Ингэснээр аймгийн төвийн иргэдийн ундны усны эх үүсвэр бохирдох эрсдэлээс хамгаалагдсан. | |
| 6.3 | Аймгийн онцлогийг харуулсан аялал жуулчлалын эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулах. | 20.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Гадаад, дотоод жуулчдын тоо | 102<br>15987 | 3000<br>30000 | Монголын тэмээн сүргийн үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг өсгөх, тэмээчид, малчдын туршлага солилцуулах, тэдний хөдөлмөрийг үнэлэх, алдаршуулах, гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор "Монголын тэмээн соёл" улсын зөвлөгөөн, баяр наадмыг 2024 оны 01 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Баянхонгор хотноо зохион байгуулсан. Зөвлөгөөнд УИХ-ын дарга Г.Занданшатар, ХХААХҮЯ-ны төлөөлөл, Монголын тэмээчдийн холбоо, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-алтай, Өвөрхангай, Ховд, Завхан, Сүхбаатар, Баян-Өлгий зэрэг нийт 10 аймгийн 240 гаруй тэмээчид оролцон, 100 гаруй тэмээний парад, гурван насны хурдан тэмээний уралдаан, шилмэл буур – шилмэл ингэ, сайхан тэмээтэй ганган хос, буйл зорох – бурантаг томох төрлөөр аваргуудыг тодруулж, тэмээний гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, соёл урлагийн цогц арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Олон улсын "Торгоны зам" автомашины ралли уралдаан 2024 оны 07 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба | **100%** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | манай аймаг олон улсын ралли уралдааныг саадгүй хэвийн үргэлжлэх нөхцөлөөр ханган хамтран ажилласан. Тус уралдааны хүрээнд 13 орны 100 гаруй зохион байгуулагч, 900 гаруй тамирчин хүрэлцэн ирсэн. Баянхонгор аймагт 2024 онд нийт 51950 жуулчид ирсэн. Үүнээс гадаадын жуулчид 750, нийт 51200 жуулчид ирсэн байна. | |
| **Зорилт 7. Зам тээвэр, дэд бүтэц, хот байгуулалт, төлөвлөлт, газрын харилцааны бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 7.1 | Баянхонгор сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх. | 20.00 Замын сангийн хөрөнгө | Тоо | 0 | 55 | "Тод тунгалаг тэмдэг" ХХК-тай гэрээ байгуулж 97 ширхэг авто замын босоо тэмдэг тэмдэглэгээг хийж Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨХК-д хүлээлгэж өгсөн. | 100% |
| 7.2 | Шаардлагатай сургууль, цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгох, камержуулалтыг сайжруулах. | 82.74 Замын сангийн хөрөнгө | Тоо | 3 | 8 | Сургууль, цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгох ажлын хүрээнд тендер сонгон шалгаруулалтыг зарлаж "Тод тунгалаг тэмдэг" ХХК шалгарч гэрээ байгуулсан ба автозамын термопластик будаг, хурд сааруулагч болон шаардлагатай бараа материалыг нийлүүлж замын тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэсэн. | 70% |
| **Зорилт 8.Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд** | | | | | | | |
| 8.1 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх. | 60.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Нөөц бүрдүүлэлт | 180 | 200 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг 2020 оноос жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусгаж шийдвэрлүүлж, хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал хүн амын хаврын улиралд шаардлагатай махны нөөцийг бүрдүүлэхэд 2020, 2021 онд 75,0, 2022 онд 100,0, 2023 онд 80.0 сая төгрөг тусгаж махны | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хомсдол, үнийн хөөрөгдөлөөс сэргийлж орон нутгийн мах бэлтгэгч ААН-тэй гэрээ байгуулан ажилласан. 2024 онд аймгийн орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөг тусгасан боловч хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилт хүндэрч зудын нөхцөл байдал үүссэн тул дээрхи хөрөнгийг өвс, тэжээл худалдан авах ажилд зарцуулсан. 2024 оны хаврын махны нөөцийг аж ахуй нэгжүүд өөрсдийн нөөц боломжид тулгуурлан бэлтгэн худалдаалж эхэлсэн. "Дэвжих өлзий хишиг" ХХК нь нөөцөд 10тн үхэр, 4тн ямаа, Баянхонгор констракшны "Мах март" ХХК нь нөөцөд 300тн махыг тус тус бэлтгэж иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн. Худалдаанд ямаа-6000, хонь-10000, үхэр-12500 төгрөгийн ханштай байсан нь зах зээлийн ханштай харьцуулахад кг тутам 3000-5000 төгрөгийн хямд борлуулагдаж байв. | |
| 8.2 | Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ, Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн аж ахуй нэгж, байгууллагад зориулсан практик сургалт зохион байгуулах. | 10.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Зохион байгуулсан сургалт | 0 | 2 | Хүлэмжийн аж ахуй эрхэлэгчид болон төмс, хүнсний ногоо тариалагчдад зориулсан танхимын болон практик сургалтыг шат дараатай зохион байгуулж байна. Эхийн голын тариалан эрхлэгчдэд зориулсан танхмиын болон талбайн сургалтыг 4 дүгээр сард, 100 хүлэмжийн аж ахуйн цогцолборын ногоочдод зориулсан сургалтыг 5 дугаар сард тус тус зохион байгуулж 68 тариаланч хамруулсан. Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүнсний хувьсгал үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн аж ахуй нэгж, байгууллагад зориулсан практик сургалтыг зохион байгуулахаар МОРА ЖИ ЭЙ ГРУПП ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж сумдын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг оролцуулсан сургалтыг 09 дүгээр сарын 05-06 ны хооронд амжилттай зохион байгууллаа. | |
| 8.3 | "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах. | 30.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо | 1 | 3 | "Намрын ногоон өдрүүд-Шилмэл мал 2024" үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 20-22 ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 13 сумын 110 иргэн, аж ахуй нэгж оролцож 100 орчим сая төгрөгийн борлуулалт хийсэн бол Шилмэл малын үзэсгэлэнд 7 сумын 36 толгой мал оролцлоо. Онцлог шинэ бүтээгдэхүүнээр Их халбагант ХХК-ны Иддэг сүү, ХХААГ-ын Зохиомол хээлтүүлэг, Сондор брэндийн Гар урлал шалгарсан. Импортыг орлох, экспорт руу чиглэсэн бараа бүтээгдэхүүнээр Урт настын эх ХХК-ийн Чонон хармаг, Энгүүмэл баян ХХК-ийн Гутал, Бөмбөгөр сумын иргэн Т.Эрдмаагийн Сүлжмэл эдлэл шалгарсан. Шилдэг үйлдвэрлэл эрхлэгчээр Баянхонгор сумын иргэн Д.Лхагваа, Р.Буян нарын Сийлбэр, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Кодаш ХХК-ны Ариусал саван шалгарав. Шилдэг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээр Ерөөлтэй Элүл ХХК-ийн Жимс жимсгэнэ, Баянлиг сумын иргэн С.Чулууны Хүнсний ногоо, Очир бумбатын хишиг ХХК-ны Хүнсний ногоо шалгарлаа. Шилдэг хоршоо, шилдэг үйлдвэрлэл эрхлэгчээр "Өгөөж баян өлзийт" хоршоо Ноолууран бүтээгдэхүүнээр, "Баялаг ундрам" хоршоо Цагаан идээгээр, "Таван хошуу бүрэн" хоршоо Сүү, цагаан идээгээр шалгарсан. Шилдэг зохион байгуулалтай сумаар Бөмбөгөр, Баянхонгор, Өлзийт сумд тус тус шалгарлаа. | |
| 8.4 | Төв хангайн бүсийн ахуйн үйлчилгээний ажилчдын ур чадварын тэмцээн зохион байгуулах, ахуйн үйлчилгээ болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг туршлага судлуулах. | 20.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хүн | 0 | 45 | Төв, хангай, говийн бүсийн Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын ахуйн үйлчилгээний ажилчдын ур чадварын тэмцээн 04 сарын 17-19-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа. Тэмцээний зорилго нь ахуйн үйлчилгээний салбарын орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг олон нийтэд сурталчлах, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжил, мэргэшлийн ур чадвар, бүтээлч хандлагыг дээшлүүлэх зорилготой. Уг арга хэмжээнд 120 орчим оролцогч, дагалдах албаны хүмүүс, дасгалжуулагчдын хамтаар ирж оролцож 15 төрөлд 350 гаруй бүтээлээ уралдуулан шилдгүүдээ тодруулсан. | 100% |
| 8.5 | Аймгийн бизнес | 60,00 | Хамрагдсан | 0 | 10 | БНХАУ-ын Гуанжу хотод зохион | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрхлэгчдийг туршлага судлуулах. | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | бизнес эрхлэгчийн тоо | | | байгуулагдсан Canton fair олон улсын томоохон худалдаа барилга, тоног төхөөрөмж, гэр ахуй, засал чимэглэл, тавилгийн үзэсгэлэн худалдаанд аймгийн 60 бизнес эрхлэгчдийг 2 ээлжээр оролцуууллаа. | |
| **Зорилт 9: Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах** | | | | | | | |
| 9.1 | "Соёлтой Баянхонгорчууд" арга хэмжээг хэрэгжүүлэх. | 10.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Гүйцэтгэл | 30 | 70 | "Соёлтой Баянхонгорчууд" 2022-2025 онд хэрэгжүүлэх 31 арга хэмжээг хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 58 хувьтай. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр "Соёлын хөтөч"-ийг 19 сумын соёлын төвд бэлтгэж салбарын хэмжээнд 89 арга хэмжээг зохион байгуулж, 52395 иргэн, 22518 хүүхэд, 595 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёлын боловсрол олгох соёл, урлагаар үйлчилж, Орон нутаг болон байгууллагаас 35.9 сая төгрөг зарцуулсан. | 70% |
| 9.2 | Ламын гэгээн Лувсанданзанжанцанд бат оршил өргөх арга хэмжээг зохион байгуулах /380 жилийн ой/ | 150.00 Орон нутгийн хөгжлийн сан | Арга хэмжээ зохион байгуулсан тоо | 0 | 1 | Ламынгэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний 385 жилийн ойн арга хэмжээг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг болон дэд ажлын хэсгүүдийг байгуулан 2024 оны 07 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулсан. | 100% |
| 9.3 | Ламын гэгээний их тойром шагайн харвааны тэмцээн зохион байгуулах | 40.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх | Гүйцэтгэл | 0 | 100 | Ламын гэгээний их тойром шагайн харвааны тэмцээнийг 2024 оны 07 дугаар сард зохион байгуулж, 45 багийн 400 орчим харваачид оролцлоо. Үүнээс улсын цолтой | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний зардал | | | | харваач 35, аймгийн Гарамгай мэргэн 87 харваачид өрсөлдөж шилдгүүдийг тодруулж, 40,0 сая төгрөгөөр урамшуулсан. | |
| **Зорилт 10: Хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлж, Монгол ахуй, ёс заншил, өв уламжлал, хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 10.1 | Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан монгол тоглоом наадгайгаар наадах гарын авлага боловсруулж, эцэг эхчүүдэд хүргүүлэх | 10.0 сая /Улсын төсөв/ | Гарын авлага боловсруулсан эсэх, Гарын авлага хүргүүлсэн өрхийн тоо | -Үгүй<br>-0 | -Тийм<br>-2000 | Монгол Улсын Боловсролын тэргүүний ажилтан тэргүүлэх, ахмад багш Д.Рина "Монгол тоглоом наадгайгаар хүүхэд хөгжүүлэх" гарын авлага боловсруулж, хэвлэлийн эх бэлтгэлд шилжүүлсэн. | 70% |
| 10.2 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх аян зарлах | - | Анхан шатны мэдлэгтэй ТАХ-ын тоо, Аян зарлагдсан эсэх | -2000<br>-үгүй | -3500<br>-тийм | "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тогтоох судалгаа"-нд 5544 хамрагдахаас 4541 албан хаагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан албан хаагчийн 65 хувь 3600 албан хаагч анхан шатны мэдлэгтэй, 25 хувь буюу 1380 албан хаагч дунд түвшний мэдлэгтэй, ахисан түвшний мэдлэгтэй 550 гаруй албан хаагч байна. | 100% |
| 10.3 | ЕБС-ын сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон Монгол зан заншил, өв уламжлалыг таниулах арга хэмжээг зохион байгуулах | 10.0 сая /Улсын төсөв/ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан сурагчдын тоо | -50<br>-10.000 | -60<br>-15.000 | ЕБС-ын сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон Монгол зан заншил, өв уламжлалыг таниулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Төсөв шийдэгдлээгүйн улмаас хэрэгжээгүй. | 30% |
| 10.4 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, салбар дундын уялдаа холбоог сайжруулах | 1.0 | хуралдсан тоо дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны тоо | 1<br>1 | 5<br>10 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ технологи, инновац бүхий шинэлэг санаа, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулж, бизнесээ эхлүүлэх, гараані дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор 75 залууд гараaны бизнесийн сургалт зохион байгуулж, 7.8 сая төгрөг зарцуулсан. Шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, 1 шилдэг гарааны бизнесийн багт 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 2 шинэ ажлын байр бий болсон. Залуучуудын эрүүл мэнд, өсвөр насныхны эрүүл мэнд болоод боловсролд чиглэсэн үзлэг, сургалт, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд давхардсан тоогоор 14771 залуучууд хамрагдаж 8451 буюу 57.2 хувиас өвчлөл илэрч, илэрсэн эмгэгийг эмчлэн эрүүлжүүлж байна. "Эрчүүдийн эрүүлд мэнд, сэтгэлзүйн онцлог","Өсвөр үеийн эрүүл мэнд" сэдвийн хүрээнд 87.5 цагийн 27 удаагийн багц сургалтуудыг 6139 залуучуудад хийж сургалтын дараах мэдлэг 75 хувиар өссөн үр дүнтэй байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/196 дугаар захирамжаар Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Жил бүр гишүүдийн санал зөвлөмжийг тусган үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг тусган батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.5 | Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал 10 модуль сургалтыг зохион байгуулж залуучуудын жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэх | 1.5 | Сургалтад хамрагдсан залуучуудын тоо | 320 | 480 | "Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал" болон амьдрах ухааны 11 модуль сургалтыг 730 залуучуудад зохион байгуулсан. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих ажлын хүрээнд оюутны эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын сайн дурын сургагч бэлтгэх ажлуудыг хэрэгжүүлж хариуцлагатай 104 залуу элчийг бэлтгэсэн. | 100% |
| 10.6 | Залуучууд судлалыг хөгжүүлж залуучуудын эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих | 2.0 | Эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон залуучуудын тоо | - | 5 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн тэргүүний нэрэмжит залуучууд судлалыг хөгжүүлэх "Залуучуудын манлайлал" эрдэм шинжилгээний бага хурлыг 2 үе шаттай зохион байгууллаа. Нэгдүгээр шатанд 17 бүтээл ирснээс 5 бүтээлийг шалгаруулж таван байр эзлүүлэн батламж, мөнгөн шагнал олгосон. Тэргүүн байр-"Ажлын байран дахь залуучуудын манлайлал" сэдвээр Ж.Жамбалдорж, Дэд байр -"Залуучууд орон нутагт амьдрах боломжийг сайжруулах нь" сэдвээр Г.Сувданцэцэг, Гутгаар байр-"Залуучуудын манлайлал багийн ажиллагаа" сэдвээр Б.Долгормаа Д.Дүүриймаа, Тусгай байр-"Гэр бүл дэх залуучуудын манлайлал" сэдвээр О.Мөнхболор, Г.Алтантуул Тусгай байр-"Ажлын байран дахь байр-"Ажлын байран дахь залуучуудын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | манлайлал судалгааны үр дүнгээс" сэдвээр Б.Саранчимэг нар шалгарсан. | |
| **11. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх** | | | | | | | |
| 11.1 | Малчдын хүүхдийн хамрагдаж байгаа сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг тоног төхөөрөмжөөр хангах. | 1,000,00 Улсын төсөв | Тоног төхөөрөмжийн хангалт | 0 | 100 | Төрийн өмчийн 36 цэцэрлэгт 99.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүн таблет зэргийг нийлүүлж, сургуулийн өмнөх насны 3150 хүүхэд хамрагдаж хүүхдийн сурах, хөгжих орчныг сайжруулсан. Тоног төхөөрөмжийн хангалт 100%. | 100% |
| 11.2 | Төрөлжсөн хичээлүүдийн улсын олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулах. | 40.00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Урамшуулал олгосон багш, сурагчид | 5/3 | 5/3 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/531 захирамжаар ЭЕШ, Улсын төрөлжсөн хичээлүүдийн олимпиад уралдаан тэмцээнд амжилт гаргасан 5 багш, 3 сурагчид 10.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. | 100% |
| 11.3 | Боловсролын салбарын багш нарыг техник, тоног төхөөрөмжөөр хангах. | 1,500.00 Улсын төсөв | Компьютероор хангагдсан багш | 600 | 1200 | Ерөнхий боловсролын сургуулийн 1200 багшид компьютер, chroomebook 45, смарт телевизор 45 нийлүүлэгдэж хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Сургалтын тоног төхөөрөмжийн хангалт, цахим орчинг сайжруулснаар багш, удирдах ажилтнууд ажлын байрандаа хөгжих, мэргэжлийн бүлгээр хамтран багшийн тасралтгүй хөгжлөөр хангах нөхцөл бүрдсэн. | 100% |
| **Зорилт 12: Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 12.1 | Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний "Жаргалтай амьдрал төв"-ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг | 200,0 Хөгжлийн төлөвлөгөө | Гүйцэтгэл | 100 | 100 | Жаргалтай амьдрал" төвд 93 хүн эмчилгээнд хамрагдсанаас гэр бүлийн хүчирхийлэл удаа дараа үйлдсэн 45 этгээдийг эмийн эмчилгээнд хамруулсан. Зөрчлийн улмаас | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэх | хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | | | | баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, амьдралын зөрэг хандлага, зөв дадалтай болгон төлөвшүүлэх зорилгоор "Зан үйлд нөлөөлөх албадан сургалт"-ыг 406 удаа 806 этгээдэд зохион байгуулсан. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 31 хувь нь өөрийн хүсэлтээр болон тус төвийн албан хаагчдын санал болгосны дагуу, 21 хувь нь ар гэрийн хүсэлтээр, 48 хувь нь Хамтарсан багаар дамжуулан үйлчилгээ авсан. Байгууллагад суурилсан нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх дэмжих бүлгийг эхлүүлж 50 иргэн хамрагдсан. "Сэтгэл зүй", "Нийгэм, хууль эрх зүйн үйлчилгээний мэдээллээр ханах сургалт" зохион байгуулж 69 байгууллагын 1832 ажилтан, албан хаагчдад хүрч ажилласан. Төвийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Төрийн болон төрийн бус байгууллагуудын 83 хувь, ажилтан, албан хаагчдын 56 хувьд хүрч ажилласан. | |
| 12.2 | Хөдөөгийн айл өрхүүдийг эрүүл мэндийн анхан шатны тоног төхөөрөмжөөх хангах | 1,000,0 Улсын төсөв | Хангалт | 85 | 90 | Хөдөөгийн айл өрхүүдэд анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх арга хэмжээний 1-р багцад: Эхо аппарат /Хүрээмарал, Жинст, Гурванбулаг, Заг, Энхбүрд ӨЭМТ-дэд/ 2-р багцад: | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Багийн эмчийн багц 92 ширхэг 3-р багцад: Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд асаргааны багц 4-р багцад: Айл өрхийг дэмжих багцыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус тус хүлээлгэн өгч эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдсэн. Монгол улсын Шадар сайдын 2024 оны 103 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2024 оны 06 дугаар тушаалаар сумдад ажиллах шуурхай бүлгүүд 20 сумын малчин өрхийн зудын эрсдэлийн үнэлгээг газар дээр хийж, 0-5 насны "Дархлаа дэмжих багц" 160 өрхөд, "Гэрийн эмийн сан"-ийн багцийг 16 өрхөд хүлээлгэн өгч ажилласан. | |
| 12.3 | Эрүүл мэндийн салбарыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах. | 900,0 Улсын төсөв | Хангалт | 85 | 90 | Эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх улсын төсвийн 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг зарлаж, "Сүвэн уул" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг хүлээн авсан. | 100% |
| 12.4 | "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | 20,0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Биелэлт | 0 | 75 | Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөний хүрээнд "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай. Тус төлөвлөгөөний хүрээнд "Хичээлийн завсарлагааны дасгал", "Бүжгээр эрүүлжье", "Эрүүл чийрэг эр хүн" зэрэг аянуудыг зохион байгуулсан. Үр дүнд өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өмнөх онд 8.7 байсан бол 2024 онд 6.7 хувиар, вируст гепатитын өвчлөлийн түвшин 10 000 хүн амд 0.1 болж өмнөх оноос 0.5 хувиар, хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин өмнөх онд 1.2 байсан бол 2024 онд 1 тохиолдол бүртгэгдэж 0.3 болж тус тус буурсан. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан албан хаагч, иргэд 1652 хүн ажлын байрандаа "Түмэн дасгал"-ыг тогтмол хийж хэвшсэн. | |
| **Зорилт 13: Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулах** | | | | | | | |
| 13.1 | Нийгмийн халамжийн сангаас олгогдох тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгох ажлыг хэрэгжүүлэх | 58,000,00 Улсын төсөв | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн | 68620 | 69220 | Нийгмийн халамжийн сангаас үзүүлэх халамжийн үйлчилгээнд 73430 иргэнийг хамруулж, 9.702.9 сая төгрөгийг хүндрэл чирэгдэлгүй олгосон. | 100% |
| 13.2 | "Хүмүүнлэгийн ордон"-ы үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх | 120,00 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Гүйцэтгэл | 0 | 13 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/12 дугаар захирамжаар Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шилжүүлсэн Ордны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 120.0 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд батлан, санхүүжүүлсэн. | 100% |
| 13.3 | Баянхонгор сумын 2, 6 дугаар багийн иргэдэд гэр олгох. | **130,0** Орон нутгийн хөгжлийн сан | Олгосон иргэдийн тоо | | | Баянхонгор сумын Эрдэнэмандал багийн **4** өрхөд гэр олгосон. Орон нутгийн хөгжлийн сангаас 20.0 сая төгрөг зарцуулсан. Баянхонгор сумын Гэгээншавь багийн 6 дугаар багийн шаардлагатай өрхүүдэд гэр олгох тендерт "Эл гранд" ХХК шалгарч 22 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орхөд 110.0 сая төгрөгөөр гэр олгоход бэлэн болсон. | |
| **Зорилт 14: Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг нэмэгдүүлж, эрүүл, идэвхтэй амьдралыг бий болгох** | | | | | | | |
| 14.1 | Улс, Тив, Дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх. | 40,00 | Гүйцэтгэл | 90.0 | 100 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/647 дугаар захирамжаар Улс, Тив, Дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн 105 тамирчин, 16 спортын холбоодод 40.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100% |
| 14.2 | Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмжөөр хангах. | 600,0 | Гүйцэтгэл | 0 | 100 | Биеийн тамир, спортын салбарыг тоног төхөөрөмжөөр хангах тендер шалгаруулалтад "Тэнгэрийн Уул" ХХК шалгарч, гэрээний дагуу нийлүүлсэн. | 100% |
| 14.3 | Эрэлт, хэрэгцээтэй мэргэжилтэй ажилчин бэлтгэх, ажлын байраар хангах. | Байгууллагын төсөв Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Бэлтгэсэн мэргэжилтэн Ажлын байрны хангалт | 404<br>270 | 450<br>315 | 2023-2024 оны хичээлийн жилд мэргэжлийн жилийн сургалттай барилгын өрөг угсрагч, барилгын засал чимэглэлчин, үсчин, цахим, тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан 4 мэргэжлээр 72 төгсөгч, техникийн боловсролын 1.5 жилийн сургалттай барилга, угсралтын техникч, оёдлын техник технологич, цахилгааны техникч гэсэн 3 мэргэжлээр 42 төгсөгч, нийт 114 суралцагчийн төгсөлтийн үнэлгээг зохион байгуулж диплом, мэргэжлийн үнэмлэхийг олгосон. Ажлын байрны хангалтын 56 хувьтай. | 100% |
| 14.4 | Ойжуулагч, сүү, сүүн бүтээгдэхүүний ажилтан, хүнсний ногооны фермер бэлтгэх. | 800,00 БШУЯ Тэтгэлэг | Бэлтгэсэн ажилтан | 300 | 400 | Ойжуулалт мэргэжлээр 134, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн мэргэжлээр 132, газар тариалангийн мэргэжлээр 134, нийт 400 суралцагч төгссөн. Ажлын байрны хангалт 72 хувьтай. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14.5 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх. | 13.30 Улсын төсөв | Шинээр бий болсон ажлын байр | 1092 | 1992 | 49.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:<br>- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд 2432 иргэн<br>- Ажилд зуучлах үйлчилгээнд 2002 иргэн<br>- Хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээг /профайлинг/ 600 иргэнд<br>-Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээнд 300 иргэнийг хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд шинээр 1194 ажлын байр бий болж 46.7 хувь буюу 558-н байнгын ажлын байр байна. | 100% |
| 14.6 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах. | 28,50 Улсын төсөв | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн иргэд | 1840 | 2300 | Хөдөлмөр эрхлэлтийн суурь ур чадвар болох зөөлөн ур чадварын сургалтыг 275 залуучууд, ажил хайгч иргэдэд хувь хүний хөгжлийн ур чадвар, харилцаа, сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулж 8.2 сая төгрөг зарцуулсан. Танхимын болон үйлдвэрлэлийн сургалтад 6 мэргэжлээр 117 иргэн хамрагдаж 67.2 сая төгрөгийг зарцуулсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зээлийн өмнөх ба дараах сургалтыг 320 иргэнд зохион байгуулж 6.0 сая төгрөг зарцуулсан. Залуучуудад аж ахуй эрхлэх зөвлөгөө сургалтыг 75 залуучуудад зохион байгуулж 7.8 сая төгрөгийг зарцуулсан. Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны сургалтыг эрх бүхий байгууллагатай хамтран | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нярав, архив албан хэрэг хөтлөгч мэргэжлээр зорилтот бүлгийн 40 иргэн хамрагдаж, 8.8 сая төгрөгийг зарцуулсан. Нийт 827 иргэн сургалтуудад хамрагдаж танхимын сургалтаас 34 ажлын байр бий болсон. | |
| | | 13,30 Улсын төсөв | Ажлын байранд зуучилсан иргэд | 1800 | 1900 | Ажил олгогчдоос ирүүлсэн 2164 сул ажлын байрны захиалгад 2002 иргэнийг зуучилж 14.0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 1215 ажлын байр, ажил олгогчдоос ирүүлсэн сул ажлын ажлын байранд 787 иргэнийг холбон зуучилж ажилласан. Ажилд зуучлагдсан 2002 иргэнээс 68.2 хувь буюу 1366 байнгын ажлын байраар хангагдсан. | 100% |
| 14.7 | Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангах. | 1,0 Байгууллагын төсөв | Сайн дурын даатгалд шинээр хамрагдсан иргэд | 180 | 380 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлж сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Гуравдугаар улирлын байдлаар 5469 иргэн нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдсанаас малчин 4553, үүнээс 230 нь шинээр хамрагдсан малчид байна. | 100% |
| **Зорилт-15. Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах замаар төсвийн үр ашгийг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах** | | | | | | | |
| 15.1 | Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн шинэ системийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх. | 10.0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ зардал | Систем нэвтрэлтийн хувь | 0% | 100% | И-Баланс цахим системийг нэвтрэлтийн нэгдсэн системд холбох үйл ажиллагаа хэрэгжиж нийт 1717 аж ахуйн нэгжээс 1408 аж ахуйн нэгж байгууллага холбогдож, системийн нэвтрэлт 82 хувьтай байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15.2 | Төсвийн ил тод байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор "Иргэдийн төсөв" Баянхонгор товхимлыг боловсруулан олон нийтэд хүргэх. | 6.0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Аймгийн 2024 оны төсвийг ил тод мэдээлсэн байх | 0 | 1000 | MASAM II төслөөс боловсруулсан загвар маягтыг боловсруулж хэвлэлтэд шилжүүлсэн болович хэвлэлийн кампанийн ачааллаас болж ондоо багтаан хэвлэлтээс гаргаагүй тул цаг үеийн ач холбогдол нь багассан учраас хэвлэлт хийгдээгүй | 90% |
| **Зорилт-16. Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах замаар татварын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулан, улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 16.1 | Хөрөнгийн татвар төлөгчдийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг зохион байгуулах, бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг бүртгэж, татварт хамруулах. | 7,0 Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Төсвийн орлогын гүйцэтгэл | 1. 68<br>2. 1100 | 1. 90<br>2.1330 | 2024 онд шинээр 21 галт зэвсэг эзэмшигч, 11 үл хөдлөх хөрөнгийг шинээр бүртгэж, ногдуулалтыг хийж ажиллалаа. 2024 оны жилийн эцсийн мэдээгээр авто тээврийн хэрэгслийн албан татвараар 650.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 726.6 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 658.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 667.5 сая төгрөг, галт зэвсгийн албан татвараар 76.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 82.9 сая төгрөг төвлөрүүлж хөрөнгийн татварын орлогын гүйцэтгэл 1385.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1477.0 сая төгрөг төвлөрүүлж 92.0 сая төгрөг буюу 107 хувиар давж биелсэн байна. | 100% |
| 16.2 | Өмнөх оны гүйцэтгэлээр нэр төрлөөр тасарсан татварын орлого дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах | Байгууллагын төсвөөс | Нэр төрөл тус бүр дээр орлогын төлөвлөгөөг биелүүлэх | 24,5 тэрбум | 25,8 тэрбум | Өмнөх оны тасарсан татварын орлогын нэр төрөл дээр дүн шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын 2024 оны "Төсвийн орлого нэмэгдүүлэх, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай" албан даалгавар, 2024 оны А/596 тоот "Татварын орлого хураалтыг эрчимжүүлэх аян зохион байгуулах тухай" захирамжаар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласны үр дүнд жилийн эцсийн орлогын мэдээгээр орон нутгийн татварын орлого 33,1 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 38,5 тэрбум төгрөг төвлөрүүлж 5,4 тэрбум төгрөгөөр буюу 116,4 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. | |
| **Зорилт-17. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж орон нутгийн бодлогын алдаа дутагдлыг тухай бүр залруулах** | | | | | | | |
| 17.1 | Төрийн байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем bayankhongor.igovernment.mn цахим сангийн хөгжүүлэлт хийх. | 15 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Хүлээн авах тайлан | 1193 | 1851 | Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг 17 төрлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайлангаар үнэлж, дүгнэдэг үүнээс 15 тайланг цахим системээр авч дүгнэдэг. Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар боловсруулсан, Засгийн газрын тэргүүлэх чиглэлийг дүгнэх журам батлагдаагүйгээс 2 тайланг цаасан хэлбэрээр авч үнэлж, дүгнэж байна. | 100% |
| 17.2 | Төрийн байгууллагуудын хөгжлийн бодлого төлөвлөлт, хяналт, хэрэгжүүлэлт сургалтыг 20 сум, 23 агентлаг, 10 орон нутгийн болон төрийн өмчийн байгууллагуудад хийх. | 20 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Сургалтад хамрагдсан байгууллага | 0 | 53 | “Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” сургалтыг 11 дүгээр сард удирдлагын академиас бэлтгэгдсэн сургагч нар хийсэн. Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газартай хамтран “Үнэлгээний нийтлэг журам”, “Мониторингийн нийтлэг журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилтийг дүгнэх журам” -ын хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ, агентлагуудын удирдлагууд, албан хаагчид нийт 67 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-18.Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 18.1 | Аймгийн цэрэг халалт, татлагын ажлыг зохион байгуулах, | 20.00 Хөгжлийн төлөвлөгөө | Хамрагдсан хүн | 2500 | 3000 | Аймгийн 2024 оны I, II ээлжийн хугацаат цэргийн албаны халалт, татлагын ажлыг 04 дүгээр сарын 17-30, 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргээс халагдан ирсэн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг Баганат талбайд нутгийн удирдлагууд, тэдний эцэг, эх, ар гэрийн төлөөллүүдийн хамт ёслол төгөлдөр угтан авч аймгийн Засаг даргын Батламж болон сумын нэрэмжит шагналуудыг гардуулан баяр хүргэсэн. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 1в/1429, 1в/3493, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны 02/1264 дугаартай албан даалгавруудыг удирдлага болгон ажиллаж, хяналтын тоог нэгдүгээр ээлжийн татлагаар 63.7%, хоёрдугаар ээлжийн татлагаар 100% тус тус биелүүлсэн. | 100% |
| 18.2 | Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, боловсролыг дээшлүүлэх. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах. /Зэвсэгт хүчний 143-р салбар/ | Хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Бэлэн байдлын хангалт | 0 | 1 | Ээлжит цэрэг татлага бүрд цэргийн насны залуучуудын 60 гаруй хувь нь эрүүл мэндээр тэнцэхгүй чөлөөлснөөс 20 гаруй хувь нь эмчлэгдэн эдгэрэх боломжтой байна. 2023 оны II, 2024 оны I ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй чөлөөлөгдсөн эмчлэгдэх боломжтой залуусын судалгааг гарган Эрүүл мэндийн газарт хүргүүлж "Эрүүлжүүлэх | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөө" боловсруулан ажилласан. Аймгийн 2024 оны II ээлжийн цэрэг татлагаар өмнө нь эрүүл мэндээр тэнцээгүй эмчлэгдэх боломжтой залуусын 5,7% нь эдгэрсэн үзүүлэлттэй. Цэрэг татлагаар нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-д заасан эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн иргэдийг **"ЭРТ ИЛРҮҮЛЭГ"**-т хамруулан 8 төрлийн шинжилгээг бүрэн хийж, эрүүл мэндийн хуудсанд хавсаргасан байна. | |
| 18.3 | Иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах. | хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | | | | Цэргийн дүйцүүлэх албаны "Тусгай үүргийн бэлтгэл шатны", "Бэлтгэл шат"-ны сургалтыг 06 дугаар сарын 02-16-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хээрийн байрлалд тус тус зохион байгуулсан. Сургалтад 2023-2025 онд алба хаах 36 иргэн, 2024-2026 онд цэргийн дүйцүүлэх албыг хаах нийт 20 сумын 40 иргэн хамрагдаж цэргийн дүйцүүлэх алба хаах гэрээг байгуулсан.Мөн дүйцүүлэх алба хаах журмын дагуу орон нутагтаа бүтээн байгуулалтын ажилд үүрэг гүйцэтгэж 100 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх 7 суманд хуваарилагдаж бүтээн байгуулалтын ажилд оролцсон. | 100% |
| 18.4 | Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн ангид алба хааж буй | 15.00 Хөгжлийн төлөвлөгөө | Хамрагдсан хүн | 100 | 300 | 2024 оны нэгдүгээр ээлжээр цэргийн албанд татагдсан Хилийн цэргийн 0166 дугаар ангид хугацаат цэргийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дайчидтай уулзалт зохион байгуулах, албаны үйл ажиллагаатай танилцах. | хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | | | | дайчидтай уулзалт зохион байгуулах, цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 21-24-ны өдрүүдэд зохион байгуулан явуулсан. Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид 2023 оны II ээлжээр татагдан ирсэн Баянхонгор, Баян-Өлгий, Завхан аймгуудын халагдах хугацаат цэргийн албан хаагчдад Тамгын газрын дарга Д.Энхжаргал алба хаагчдын хамт иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор "Халагдах цэргийн вальс" үдэшлэг зохион байгуулж гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулан орон нутгийн хэвлэл, мэдээллээр сурталчилсан. | |
| **Зорилт-19. Байгууллагын өдөр тутмын алба үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад бэлэн байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх** | | | | | | | |
| 19.1 | Аймгийн засаг даргын тамгын газрын ажлын албанд шаардлагатай автомашин худалдан авах. | 300,0 сая Бусад эх үүсвэр | Худалдан авсан автомашины тоо | 2 | 4 | Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2024 онд албан хэрэгцээнд шаардлагатай байсан Toyota crown -210, Toyota Land -200, суудлын 2, тээврийн Porter-II маркийн автомашиныг худалдан авч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. | 100% |
| 19.2 | Нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ үйлчилгээ, урсгал засварыг тогтмол хийх | Байгууллагын төсөв | -Үнэлгээний хувь,<br>-Урсгал засварын тоо | -100%<br>-4 | -100%<br>-6 | Нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж албан хаагчдын ая тухайтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулж тоног төхөөрөмжийн хангалт хийж, хүчин чадал сайтай тоос сорогч, хивс цэвэрлэгч худалдан авч | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын хөрөнгөд бүртгэсэн. Байгууллагын дотор болон гадна урсгал засвар, тасалгааны тохижилтод нийт 6 засвар үйлчилгээг хийсэн. | |
| 19.3 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, гэрэлтүүлэг, цахилгааны материал, автомашин, сэлбэг, хурлын танхимын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Байгууллагын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Автомашины засвар оношилгоо үйлчилгээг цаг тухай бүрд нь хийлгэж тос масло тогтмол сольж хэвшиж завсар үйлчилгээнд 77,9 сая төгрөг зарцуулж бэлэн байдлыг хангасан. Байгууллагын гадна дотор гэрэлтүүлгийг цаг тухай бүр шинэчлэн сайжруулах ажил хийгдэж хурлын танхимд болон ЗДТГ-ын даргын өрөөнд сургалтын ухаалаг самбар байршуулсан. Дотор камержуулалтыг бүрэн шинэчилж хурлын танхимын хаалга болон ширээ сандал, дэвсгэрийг бүрэн шинэчилж тохижуулсан. Мөн хурлын танхимын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 19.4 | Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх | - | Хуулийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэн нийгмийн даатгал, татвар, санхүүгийн жилийн эцсийн тайлан балансыг гарган ажилласан. | 100% |
| **Зорилт-20. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 20.1 | Авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлэх контентыг бүтээж, түгээх | - | Бүтээсэн контентын тоо | - | 2 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд Улс төрийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт, шударга хүүхэд нэртэй 2 контентыг 1.500.000 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээлгэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. | |
| 20.2 | Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ | | Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлсэн тоо | - | 1 | Аймгийн сэтгүүлч нарын дунд “Авлигыг тэвчиж үл болно” уралдааны зарласны үр дүнд 3 сэтгүүлч оролцон бүтээл ирүүлж контент-6 ширхэг, авлигын мэдээ-3 ширхэг, сонины нийлэл 3 ширхэг, постер 3 ширхэг тус тус бүтээгдэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. | 100% |
| 20.3 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ | - | Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан иргэний нийгмийн байгууллагын тоо | - | 2 | Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран төрөөс ЖДҮ нарт зээл, санхүүжилт олгох төсөл хөтөлбөр хариуцан ажилладаг ажилтнуудын төлөөлөл болсон 40 албан хаагчид зориулан авлигаас ангид байх сургалтыг зохион байгуулж байгуулж хууль, эрх зүйн мэдлэг олгосон. Мөн иргэний нийгмийн байгууллагуудын дунд уралдааныг 2 удаа зарласан боловч бүтээл ирүүлээгүй бөгөөд авлигын эсрэг үйл ажиллагааг 2 төрийн бус байгууллага сурталчилж ажилласан. | 100% |
| 20.4 | Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад | - | Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх хөтөлбөрийн тоо Хамрагдсан хүүхдийн тоо | - | 1<br>500 | Авлигатай тэмцэх газрын санаачилгаар ТББ байгууллагаар хийлгэсэн улсын хэмжээний хүүхдийн шударга байдлын 2023 оны судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 2023 онд 3.97 оноотой гарсан нь 2022 оныхоос 0.1 пунктээр өссөн үзүүлэлт юм. Мөн энэхүү судалгааны үр дүнд суурилсан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна | | | | | дүнгээр хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрт авлигын эсрэг гэрэл түгээе аян, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд авлигын эсрэг чиглэсэн 5 видео бүтээгдэж 1000 гаруй хүүхдийн оролцоог ханган ажилласан. | |
| 20.5 | Нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгөх хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах, үр дүнг тооцох | | Мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээснээр үзсэн тоо Гудамж талбайн ил харагдах газарт байршуулж иргэд олон нийтэд сурталчилсан мэдээллийн тоо | | 200 5 | Авлигатай тэмцэх газрын /www.iaac.mn/ вэб сайтад байршсан Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх 5 төрлийн видео контентуудыг түгээн ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газартай хамтран аймгийн ИТХ-ийн төлөөлөгч нар болон төрийн удирдах гүйцэтгэх албан хаагчдад нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдлыг мэдэгдэх талаар мэдлэг олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан 980 хүнд сургалт зохион байгуулж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. Гудамж талбайн ил харагдах газарт авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан зурагт хуудсыг 150 ширхгийг байршуулан ажилласан. Мөн "Цахимд хэвшье" нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан "Авлигын эсрэг хамтдаа нэгдье" уриа бүхий авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан 433 ширхэг гарын авлагыг иргэд төрийн албан хаагчдад түгээсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20.6 | Сонгогчдод эрх зүйн боловсрол олгох постер бэлтгэн хэлтсийн пэйж хуудсаар иргэдэд сурталчлах | - | Бэлтгэсэн постерын тоо | - | 3 | Сонгогчдод эрх зүйн боловсрол олгох зорилгоор 3 төрлийн постер, 4 төрлийн гарын авлага бэлтгэн иргэдэд сурталчилж ажилласан. | 100% |
| 20.7 | Мөнгөн хандивыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулалтыг тухай бүр олон нийтэд ил тод тайлагнана | - | Мөнгөн хандивыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулалтыг тухай бүр олон нийтэд ил тод тайлагнасан тоо | 2.680.0 сая | 4.300.0 сая | Уул уурхайн компануудын үйл ажиллагааны орлогоос орон нутгийн хөгжлийн санд 4,3 тэрбум төвлөрүүлэхээс 1,635 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Зарцуулалтыг shilen.gov.nm -д байршуулан ил тод байдлыг ханган ажилласан. | 100% |
| 20.8 | Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед тусгай үүрэг гүйцэтгэн ажиллах байгууллагын авлигын эрсдэлийг тодорхойлж, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ | - | Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн төлөвлөгөөнүүд шинэчлэгдэн батлагдсан байх үзүүлэлтээр | 1 | 1 | Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед тусгай үүрэг гүйцэтгэн ажиллах гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн төлөвлөгөөнүүд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд 2025 оны төлөвлөгөөнд тусгасан. | 100% |

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА /Д.МӨНХСАЙХАН/

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА /Д.ЭНХЖАРГАЛ/

# БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2025 оны 01 дүгээр сарын 15 Номгон

| Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтийн товчоо | | |
|---|---|---|
| **Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо 95** | | |
| Үнээс | **Үр дүнтэй** 100% | **85** |
| | **Тодорхой үр дүнд хүрсэн** /70-90 хувь/ | **1** |
| | **Эрчимжүүлэх шаардлагатай** /30-70/ хувь/ | **7** |
| | **Үр дүнгүй** /0-30 хувь/ | **2** |
| | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж **96** хувьтай байна. | |

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА /Д.МӨНХСАЙХАН/

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА /Д.ЭНХЖАРГАЛ/